

**“ТӨВЦЭНГЭЛДЭХ ХҮРЭЭЛЭН” ХХК-ИЙН
2024 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТААР ИЛЭРСЭН
ЗӨРЧЛИЙГ АРИЛГУУЛАХ ЗӨВЛӨМЖИЙН БИЕЛЭЛТ**

2025.08.13

Улаанбаатар хот

№	Хийгдэх ажил	Биелэлт	Хувь
1	2024 оны 4 дүгээр сарын мөнгөн хөрөнгийн 37,279.8 мянган төгрөгний орлогын 70,861.6 мянган төгрөгийн зарлагын, бараа материалын 99,854.1 мянган төгрөгийн орлого, 18,045.8 мянган төгрөгийн зардлын анхан шатны баримтыг санхүүгийн тайлангийн аудитад ирүүлээгүй.	2024 оны 04 дүгээр сарын мөнгөн хөрөнгө болон бараа материалын тайлангийн орлого, зарлагын анхан шатны баримтуудыг бүрдүүлэн тайланг гаргаж, үдэж архивласан.	100
2	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлд заасны дагуу компанийн захирал эрхээ бүрэн хэрэгжүүлэн үйл ажиллагааны журам, бүтээгдэхүүний борлуулалт, маркетингийн төлөвлөгөө, байгууллагын стратеги, урт хугацааны болон дунд хугацааны бизнес төлөвлөгөө зэрэг байгууллагын өдөр тутмын хэвийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх бодлогын бичиг баримтуудыг боловсруулаагүй.	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлд заасны дагуу гүйцэтгэх захирал 2025 оны эрхээ бүрэн хэрэгжүүлэн үйл ажиллагааны журам, бүтээгдэхүүний борлуулалт, маркетингийн төлөвлөгөө, байгууллагын стратеги, урт хугацааны болон дунд хугацааны бизнес төлөвлөгөө зэрэг байгууллагын өдөр тутмын хэвийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх бодлогын бичиг баримтуудыг боловсруулан байгууллагын “Төлөөлөн удирдах зөвлөл”-ийн хурлаар хэлэлцүүлэн баталсан.	100
3	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг боловсруулаагүй	2025 онд “Эф ар эй оргил ХХК”-иар 275 хуудастай нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг баримтыг боловсруулан хийлгэсэн.	100
4	Арилжааны банканд байршуулсан мөнгөн хөрөнгийн өдрийн дундаж үлдэгдэл 2024 оны байдлаар 191,586.4 мянган төгрөг байгаа бөгөөд энэхүү хөрөнгөөс хадгаламжийн хүүгийн орлогоор, хөрөнгийн үр ашгийг нэмэгдүүлэх боломжийг хэрэгжүүлээгүй байна. Мөн харилцах данснаас зарлагын гүйлгээ хийхдээ анхан шатны баримтын бүрдлийг хангаагүй, цахим хэлбэрээр төлбөрийг гүйцэтгэсэн.	Харилцах данснаас гүйлгээг гаргахдаа анхан шатны баримтын бүрдлийг бүрэн ханган гүйцэтгэх захирлаар хянуулан гүйлгээг гаргаж байгаа бөгөөд харилцах дансны үлдэгдлээс хадгаламжийн хүү бодогдох арилжааны банкнуудын судалгааг хийж харилцахын үлдэгдлээс хүү тооцуулж байна.	90
5	Анхан шатны бүрдэл дутуу баримтаар 18,045.8 мянган төгрөгийн бараа материалын зарлагын гүйлгээг хийж, данс бүртгэлд тусгасан байна.	Бараа материалын зарлагын анхан шатны баримтуудын нөхөн бүрдүүлж, тайланг гаргаж үдэж, архивласан.	100
6	Сар бүрийн бараа материалын орлого, зардлын дүнгээр анхан шатны баримт бүрдүүлж няравын тайланг бэлтгээгүй нягтлан бодогч хянаж баталгаажуулаагүй	2025 онд бараа материалын тайлан болон кассын тайланг сар бүр анхан шатны баримтын бүрдлийг хангуулан гаргуулж, үдэж архивлан нягтлан бодогч хянан баталгаажуулж байна.	100
7	Ажилтан алба хаагчдын хэрэглэж байгаа эд хөрөнгийн ашиглалтын бүртгэлийн карт нээгээгүй, эд хөрөнгөд бүртгэлээр тавих хяналт хангалтгүй	Гүйцэтгэх захирлын 2025 оны 07 дугаар сарын 21-ний өдрийн А/24 дугаартай тушаалаар батлагдсан 13 хүний бүрэлдэхүүнтэй тооллогын комисс 2025 оны 07 дугаар сарын 23-ны өдрөөс 07 дугаар сарын 25-ны өдрийг	

		хүртлэх хугацаанд байгууллагын эд хөрөнгийг нүд үзнэ тоолж, санхүүгийн программтай тулгалт хийж баталгаажуулсан. Ажилтан алба хаагч нарт ашиглагдаж байгаа эд хөрөнгийн ашиглалтын бүртгэлийн картыг нээж, хөрөнгүүдийг коджуулсан.	90
8	Газрын гэрчилгээнд 126661м2 газар бүртгэлтэй байдаг боловч тус байгууллагын үндсэн хөрөнгийн дансанд бүртгээгүй	Газрын гэрчилгээнд бүртгэлтэй 126661м2 газрыг хуулийн дагуу 17,833,728,000.00 үнэлж үндсэн хөрөнгийн дансанд тусгасан.	100
9	Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээн дээрх дүрмийн сан, байгууллагын эзэмшиж байгаа хөрөнгийн дүнгээс зөрүүтэй	Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээн дээрх дүрмийн санг, байгууллагын эзэмшиж байгаа хөрөнгийн дүнгээр засуулахаар материалыг бүрдүүлэн хүргүүлсэн	50
10	Ажил гүйцэтгэх болон худалдах худалдан авах гэрээ байгуулж төлбөрийг гүйцэтгэхдээ гэрээний хэрэгжилтийг дүгнээгүй, үүргийн хэрэгжилтийн дүнд үндэслэн төлбөрийг төлөөгүй.	Худалдан авалт тендер хариуцсан мэрэгжилтан ажил гүйцэтгэх болон худалдах худалдан авах гэрээ байгуулж, төлбөрийг гүйцэтгэхдээ гэрээний хэрэгжилтийг дүгнэн гэрээ дүгнэсэн акт үйлдэн гэрээ биелэлт 100 хувь хэрэгжсэн үед төлбөрийг барагдуулж байна.	100
11	Бараа худалдан авахдаа цахим дэлгүүрээс худалдан аваагүй	2025 онд бараа материал худалдан авахдаа “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 9 дүгээр зүйлд заасны дагуу нийтцахим худалдан авалтыг зарлаж хийсэн.	90
12	Төсвийн хөрөнгөөр бараа ажил, үйлчилгээ худалдан авахдаа холбогдох хууль, журмыг мөрдөж ажиллаагүй.	Төсвийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авахдаа “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хууль болон бусад холбогдох хууль журмыг мөрдөн цахим худалдан авалт болон тендер зарлан авч байна.	100
13	Шилэн дансны цахим хуудаст мэдээлвэл зохих мэдээллийг байршуулаагүй.	2025 оны эхний 07 дугаар сарын байдлаар шилэн дансны хуулийн дагуу нийт 104 мэдээлэл байршуулахаас 80 мэдээллийг хуулийн хугацаанд 24 мэдээллийг хугацаа хоцроож оруулсан.	80
Дүн		1200/13	92,3